



ХАВДАР СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн чиглэлээр түгээмэл ашиглагдаж буй орчин үеийн эмчилгээ, оношилгооны шинэ арга технологиудыг эзэмшсэн байх;
2. Мэргэшлийн чиглэлээр дотоодын хуралд илтгэл хэлэлцүүлсэн байх;
3. Мэргэшлийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны бүтээл хэлэлцүүлсэн байх;
4. Мэргэшлийн чиглэлээр олон нийтэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан туршлагатай байх;
5. Мэргэшлийн чиглэлээр гадаад болон дотоодод мэргэшил дээшлүүлж байсан туршлагатай байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн чиглэлээр түгээмэл ашиглагдаж буй орчин үеийн эмчилгээ, оношилгооны шинэ арга технологиудыг эзэмшсэн байх;
2. Мэргэшлийн чиглэлээр гадаад болон дотоодын хуралд хэлэлцүүлсэн илтгэл тус бүр 1-ээс доошгүй байх;
3. Мэргэшлийн чиглэлээр бэлтгэсэн ном бүтээлтэй байх;
4. Мэргэшлийн чиглэлээр мэргэжил арга зүйн бодлогын баримт бичиг боловсруулахад санал өгсөн, ажлын хэсэгт ажилласан эсхүл төсөл хөтөлбөрт ажилласан туршлагатай байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн чиглэлээр эмчилгээ, оношилгооны шинэ арга технологи удирдан нутагшуулж, нэвтрүүлсэн байх;
2. Мэргэшлийн чиглэлээр олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байх;

3. Мэргэшлийн чиглэлээр салбартаа удирдах ажил хийсэн ажлын туршлагатай байх;
4. Мэргэшлийн чиглэлээр олон улсын чанартай хурал, зөвлөгөөн зохион байгуулж байсан туршлагатай байх;
5. Мэргэшлийн чиглэлээр бэлтгэсэн ном бүтээлтэй байх;
6. Мэргэшлийн чиглэлээр мэргэжил арга зүйн бодлогын баримт бичиг боловсруулахад санал өгсөн, ажлын хэсэгт ажилласан эсхүл төсөл хөтөлбөр удирдаж ажилласан туршлагатай байх.